



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/254

Хэрлэн сум

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын
үзлэг, тооллого зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 9, 46 дугаар тогтоол, 2021 оны 278 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг удирдан зохион байгуулахтай холбогдуулан ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, тооллогыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг удирдан зохион байгуулах салбар комиссыг бүх сумд, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагуудад байгуулж холбогдох хууль, заавар журам, төлөвлөгөөний дагуу үзлэг тооллогыг зохион байгуулахыг Засаг даргын дэргэдэх агентлагийн удирдлагууд, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Тооллогын ажлыг мэргэжил арга зүйгээр хангаж, Үндэсний статистикийн хороорноос баталсан маягт, гарын авлагуудыг орон нутгийн өмчит бүх аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Г.Лхагвахатан)-д үүрэг болгосугай.

4. Эд хөрөнгийн үзлэг тооллогыг хууль, тогтоомж, заавар, журам, төлөвлөгөөний дагуу батлагдсан төсөвт багтаан зохион байгуулж, 2022 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор нэгдсэн дүнг аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулан, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг ажлын хэсэг (С.Нямдаваа)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

2021010102



Аймгийн Засаг даргын 2022 оны

05 дугаар сарын 06 өдрийн


А/ЗЧ дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫН
АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	С.Нямдаваа	Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Ажлын хэсгийн дэд дарга	Г.Лхагвахатан	Орон нутгийн өмчийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	С.Сосорбарам	Орон нутгийн өмчийн газрын, Өмчийн бүртгэл, ашиглалт, хяналтын мэргэжилтэн
Гишүүд:	Г.Болор-Эрдэнэ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн
	Б.Төрхүү	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
	Ж.Жаргалсайхан	Автотээврийн төвийн мэргэжилтэн
	Т.Зулбаатар	Соёл, урлагийн газрын дарга
	Ш.Цамбасүрэн	Орон нутгийн өмчийн газрын өмчийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

A/054

Аймгийн Засаг даргын 2022 оны
 05 дугаар сарын 06-ны өдрийн
 05 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН 2022 ОНЫ УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГО
 ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажлууд	Хугацаа /он,сар,өдөр/	Хариуцах эзэн
0	1	2	3
1	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах салбар ажлын хэсгийг байгуулах	2022.04.25-ны өдрийн дотор	Г.Лхагвахатан
2	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах төлөвлөгөө гаргах, зардлын тооцоог гаргаж батлуулах	2022.04.25-ны өдрийн дотор	С.Сосорбарам
3	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах нэгдсэн сургалт, арга зүйн зөвлөгөө өгөх, холбогдох гарын авлага тараах	2022.04.30-ны өдрийн дотор	С.Сосорбарам Ш.Цамбасүрэн
4	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах ажилд хяналт тавих, шалгах, зөрчлийг арилгуулан заавар зөвлөгөө өгөх, нэгдсэн дүн мэдээнд баталгаажуулалт хийх	2022.05.31-ны өдрийн дотор	С.Сосорбарам Ш.Цамбасүрэн
5	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогод түүвэрчилсэн хяналтын тооллого хийх	2022.05.31-ны өдрийн дотор	Ажлын хэсэг
6	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн доод талын эзэмшлийн газрыг газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /egazar.gov.mn/-ын мэдээллийн системтэй тулган баталгаажуулж, бүртгэлд оруулах	2022.05.31-ны өдрийн дотор	Г.Болор-Эрдэнэ
7	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн тээврийн хэрэгслийг "Авто тээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын мэдээллийн системтэй тулган баталгаажуулж, бүртгэлтэй эсэхийг тогтоон бүртгэлжүүлэх	2022.05.31-ны өдрийн дотор	Ж.Жаргалсайхан
8	Орон нутгийн өмчийн тооллогод хамрагдах хуулийн этгээд, барилга /орон сууц/ жагсаалтыг гаргаж, улсын бүртгэлийн мэдээллийн сантай тулган баталгаажуулах ажлыг зохион байгуулах	2022.05.31-ны өдрийн дотор	Б.Төрхүү

9	Орон нутгийн өмчийн тооллогод хамрагдах байгууллагуудын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй түүх соёлын дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалт үнэлгээнд хяналт тавих, зарим үнэт зүйлийн судалгааг гаргаж, бүртгэлтэй эсэхийг тогтоох	2022.05.31-ны өдрийн дотор	Т.Зулбаатар
10	Орон нутгийн өмчийн байгууллагын дансанд бүртгэлтэй хуучин барилга байгууламж, тоног төхөөрөмж, худаг, уст цэгийг нүд үзэн тоолж ашиглаж байгаа болон ашиглахгүй байгаа судлагааг гаргах, солбилцолыг тогтоох	2022.05.31-ны өдрийн дотор	Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой байгууллагууд
11	Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдэд үзлэг тооллогын дүнг батлагдсан маягтаар тоолж гарган, шалган баталгаажуулж санал, дүгнэлт, тайлбар, илтгэх хуудасны хамт салбар ажлын хэсэгт хүлээлгэн өгөх	2022.06.15-ны өдрийн дотор	Ажлын хэсэг
12	ТӨБЗГ-ын мэргэжилтэнгүүдтэй хамтран төрийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагуудад хяналтын тооллого явуулах	2022.06.30-ны өдрийн дотор	Ажлын хэсэг
13	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын дүн, тайланг орон нутгийн өмчийн хуулийн этгээдээс хүлээн авч, шалган баталгаажуулж, архивын нэгж үүсгэн нэгтгэлийг аймгийн ажлын хэсэгт хүлээлгэн өгөх	2022.07.15-ны өдрийн дотор	Ажлын хэсэг
14	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын дүнгийн нэгтгэлийг шалган баталгаажуулж, санал дүгнэлт, тайлбарын хамт аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ТӨБЗГазарт хүлээлгэн өгөх	2022.07.30-ны өдрийн дотор	Ажлын хэсэг
15	Улсын үзлэг, тооллогоор данснаас хасах, актлах, шилжүүлэх, худалдах, хөрөнгийг нэг бүрчлэн гарган санал дүгнэлт боловсруулан аймгийн ИТХ-д оруулж шийдвэрлүүлэх	2022 оны 09 дүгээр сард	С.Сосорбарам Ш.Цамбасүрэн

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН

ОНӨГ-ын өмчийн бүртгэл, ашиглалт,
хяналтын мэргэжилтэн

С.Сосорбарам